



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/240

Чингис хот

Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг  
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу иргэн Мөнх-Эрдэнийн Энхтүвшиний эзэмшлийн Хэрлэн сумын 3 дугаар баг Татварын хэлтсийн баруун талд байрлах үйлдвэр үйлчилгээний зориулалттай 1189 м<sup>2</sup> газрыг "Монами мийт" ХХК-д 52 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан "Монами мийт" ХХК-тай гэрээ байгуулан, биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Д.Баярхүү/-д үүрэг болгосугай.

3. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлж авсан "Монами мийт" ХХК-ий захирал Ч.Очирбатад үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гаргасантай холбогдуулан Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын 2017 оны А/162 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА